



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/363

Булган

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Булган сумын төвийн гудамжны гэрэлтүүлгийн өөрчлөлт шинэчлэлтийн ажлын зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Улаанбаатар хотын “Дукат” ХХК-тай 11.000.000 /арван нэгэн сая/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

3. Гэрээний хугацаанд дээрх ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Дукат” ХХК /С.Алтанцэцэг/-д даалгасугай.

4. Энэхүү ажлын санхүүжилтыг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ